

ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД САНАЛ

2025 оны 05 сарын 19-ний өдөр

Хувийн нэмэлт тэтгэвэрийн тухай хуулийн хуулийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

Хувийн нэмэлт тэтгэвэрийн тухай хуулийн төсөл:	Санал: Нэмэх, Өөрчлөх, Хасах	Тайлбар:
9 дүгээр зүйл. 9.6. хэсэгт заасан Ажил олгогч төлөөгүй шимтгэлийг төлсөн буюу хувийн тэтгэвэрийн сан, урт хугацааны даатгагчид шилжүүлсэн өдрөөс хойш аливаа өгөөж бодогдоно.	Өөрчлөх: 9 дүгээр зүйл. 9.6. хэсэг “Энэ хуулийн 7.2. дахь хэсэгт заасан гэрээг байгуулсан ажил олгогч мөн хуулийн 8.6. дахь хэсэгт заасан өдрөөс эхлэн хувийн тэтгэвэрийн сан, урт хугацааны даатгагчид шимтгэлийг шилжүүлсэн эсэхээс үл хамаарч аливаа өгөөж бодогдоно.”	Учир нь Энэ хуулийн 40 дүгээр зүйл. 40.1 дэх хэсэгт Хувийн тэтгэвэрийн сан, урт хугацааны даатгагч нэмэлт тэтгэвэрийн хөтөлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгэнэ гэж заасан байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулинд 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно: 3.1.1."нягтлан бодох бүртгэлийн аккрузл суурь" гэж мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг; хэлнэ гэж зааснаас харвал энэ хуулийн 9.6. дахь хэсэгт Ажил олгогч төлөөгүй шимтгэлийг төлсөн буюу хувийн тэтгэвэрийн сан, урт хугацааны даатгагчид шилжүүлсэн өдрөөс хойш аливаа өгөөж бодогдохоор тусгасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн нягтлан бодох бүртгэлийн аккрузл сууриар бүртгэх зарчимтай зөрчилдөж байх тул мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч өөрөөр хэлвэл төлсөн буюу шилжүүлсэн

		эсэхээс үл хамаарч, тайлагнасан хугацаанаас эхлэн хувийн тэтгэвэрийн сан, урт хугацааны даатгагчид өгөөжийг тооцоолж гишүүний нэрийн дансанд хуримтлуулах ёстой гэж үзэж байна.
--	--	---